

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/28/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,  
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ  
Утас: 262071 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунжаргал  
Утас: 262071 Цахим хаяг: Ariunjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН  
КОМИССЫН ДАРГА С.ОДОНТУЯА  
ТАНАА

2024.04.25 № 1134  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайлагналын иж бүрэн, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа босго үнийг баримтлалгүй 68.0 сая төгрөгийн нэг төрлийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан;
- Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангаагүй 90.7 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 105.5 сая төгрөгийн 39 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй

зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 4.1.3, 4.1.6, 15 дугаар зүйлийн 15.1.6, 15.2.3 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын комиссын дүрэм болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Иргэний хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу 2023 онд 340 иргэнд 14,315.1 сая төгрөгийн нөхөх олговор олгохоор батлагдсанаас 40.0 сая төгрөгийн нөхөх олговрыг 271 иргэнд 10,840.0 сая, 80.0 сая төгрөгийн нөхөх олговрыг 43 иргэнд 3,440.0 сая төгрөг, 5 иргэнд 20.0 сая төгрөг, нийт 319 иргэнд 14,300.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олгосон байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд Бүгд Найрамдах Солонгос Улсын улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүх, хор уршиг, үр дагаврыг арилгах, соён гэгээрүүлэх нөлөөллийн чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын сайн туршлага солилцох, ижил төрлийн мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах ажиллагааг эхлүүлж 63.0 сая төгрөг зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөж, 10 арга хэмжээ 95.0 хувь, 8 арга хэмжээ 94.0 хувь, 5 арга хэмжээ 96.0 хувь, 4 арга хэмжээ 90.0 хувь, 2 арга хэмжээ 98.0, 1 арга хэмжээ 97.0 хувь хувь буюу нийт хэрэгжилт 94.5 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,412.0	44,706.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19.6	-
33	АВЛАГА	193.4	-
34	УРЬДЧИЛГАА	9,500.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	41,699.0	44,706.0
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,776.6	28,720.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,776.6	28,720.7
392	Биет хөрөнгө	18,776.6	26,169.2
393	Биет бус хөрөнгө	-	2,551.6
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>70,188.5</b>	<b>73,426.7</b>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	70,188.5	73,426.7
51	Засгийн газрын хувь оролцоо	70,188.5	73,426.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	50,239.4	50,239.4
51101	Өмч: - төрийн	50,239.4	50,239.4
512	Хуримтлагдсан үр дүн	19,117.3	23,187.3
51210	Өмнөх үеийн үр дүн	3,359.7	19,949.1
51220	Тайлант үеийн үр дүн	15,757.7	3,238.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831.8	-
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>70,188.5</b>	<b>73,426.7</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>15,311,563.0</b>	<b>15,177,376.5</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,311.6	9,204.5
120	Нийтлэг татварын бус орлого	5,311.6	9,204.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,306,251.4	15,168,172.0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>15,295,805.3</b>	<b>15,174,138.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,295,805.3	15,174,138.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	487,918.0	787,159.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	212,749.9	336,039.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,264.2	35,829.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,651.8	37,774.1
2104	Хангамж, бараа материалын зардал	11,337.5	21,674.0
2107	Томилолт, зочны зардал	7,220.2	62,869.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,057.9	273,272.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,636.5	19,700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,807,887.3	14,386,978.7
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>15,757.7</b>	<b>3,238.2</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (V)=(III)+(IV)</b>	<b>15,757.7</b>	<b>3,238.2</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	54,430.9	-	54,430.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>54,430.9</b>	-	<b>54,430.9</b>
Тайлант үеийн үр дүн	15,757.7	-	15,757.7
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>70,188.5</b>	-	<b>70,188.5</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	831.8	-	831.8
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>71,020.3</b>	-	<b>71,020.3</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(831.8)	-	(831.8)
Тайлант үеийн үр дүн	3,238.2	-	3,238.2
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>73,426.7</b>	-	<b>73,426.7</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>15,306,251.4</b>	<b>15,168,172.0</b>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,306,251.4	15,168,172.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,306,251.4	15,168,172.0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>15,306,231.8</b>	<b>15,168,191.6</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,306,231.8	15,168,191.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,344.5	781,212.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,832.4	336,039.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,026.3	35,635.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,651.8	37,774.1
2104	Хангамж, бараа материалын зардал	11,337.5	24,248.0
2107	Томилолт, зочны зардал	7,220.2	62,869.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,906.7	271,670.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,369.6	12,974.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,807,887.3</b>	<b>14,386,978.7</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,807,443.0	14,386,235.5
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	444.3	743.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>19.6</b>	<b>(19.6)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>19.6</b>	<b>(19.6)</b>
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19.6	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,189,339,800.00</b>	<b>15,167,448,412.55</b>	<b>21,891,387.45</b>	<b>99.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,189,339,800.00</b>	<b>15,167,448,412.55</b>	<b>21,891,387.45</b>	<b>99.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>783,770,900.00</b>	<b>781,212,922.55</b>	<b>2,557,977.45</b>	<b>99.7</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>336,585,600.00</b>	<b>336,039,894.70</b>	<b>545,705.30</b>	<b>99.8</b>
Үндсэн цалин	199,581,800.00	189,856,384.24	9,725,415.76	95.1
Нэмэгдэл	90,035,100.00	90,635,554.46	(600,454.46)	100.7
Унаа хоолны хөнгөлөлт	14,282,400.00	23,773,000.00	(9,490,600.00)	166.4
Урамшуулал	32,686,300.00	31,774,956.00	911,344.00	97.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>35,635,900.00</b>	<b>35,635,800.00</b>	<b>100.00</b>	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	24,332,300.00	24,332,300.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	2,950,900.00	2,950,900.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,160,900.00	2,160,900.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	590,100.00	590,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	5,601,700.00	5,601,600.00	100.00	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,774,100.00</b>	<b>37,774,100.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Байрны түрээс	37,774,100.00	37,774,100.00	-	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,229,100.00</b>	<b>24,248,004.40</b>	<b>(18,904.40)</b>	<b>100.1</b>
Бичиг хэрэг	4,668,000.00	5,356,100.00	(688,100.00)	114.7
Тээвэр, шатахуун	4,940,200.00	4,940,200.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,601,300.00	2,949,204.40	652,095.60	81.9
Ном, хэвлэл	6,810,900.00	6,770,000.00	40,900.00	99.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,208,700.00	4,232,500.00	(23,800.00)	100.6
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>62,869,600.00</b>	<b>62,869,600.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Гадаад албан томилолт	48,000,000.00	48,000,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	14,869,600.00	14,869,600.00	-	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>273,650,400.00</b>	<b>271,670,923.45</b>	<b>1,979,476.55</b>	<b>99.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	262,407,900.00	260,428,803.45	1,979,096.55	99.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,242,500.00	11,242,120.00	380.00	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,026,200.00</b>	<b>12,974,600.00</b>	<b>51,600.00</b>	<b>99.6</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	731,600.00	731,600.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,294,600.00	12,243,000.00	51,600.00	99.6
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,405,568,900.00</b>	<b>14,386,235,490.00</b>	<b>19,333,410.00</b>	<b>99.9</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,405,568,904.00</b>	<b>14,386,235,490.00</b>	<b>19,333,414.00</b>	<b>99.9</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,458,500.00	6,000,000.00	1,458,500.00	80.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,315,060,200.00	14,299,973,490.00	15,086,710.00	99.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	83,050,200.00	80,262,000.00	2,788,200.00	96.6
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>15,189,339,800.00</b>	<b>15,167,428,812.55</b>	<b>21,910,987.45</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>15,189,339,800.00</b>	<b>15,167,428,812.55</b>	<b>21,910,987.45</b>	<b>99.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	15,189,339,800.00	15,167,428,812.55	21,910,987.45	99.9
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>19,600.00</b>	<b>(19,600.00)</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>		

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	11	11	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.0
Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар 22.7 сая төгрөгийн бүртгэл тайлагналын 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөлтийг 21.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Машин, тоног төхөөрөмжийн дансанд 1.6 сая төгрөгийн веб сайтыг ангилал зөрүүлэн бүртгэсэн.

Аудитаар нийт 178.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 76.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 102.0 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 178.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ЦАУЗБУК	Машин, тоног төхөөрөмжийн дансанд 1.6 сая төгрөгийн веб сайтыг ангилал зөрүүлэн бүртгэсэн байна.	1	1.6			1	1.6	1	1.6				
	Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг 21.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	21.1			1	21.1	1	21.1				
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>22.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>22.7</b>	<b>2</b>	<b>22.7</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ЦАУЗБУК	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 105.5 сая төгрөгийн 39 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх арга хэмжээ аваагүй байна.	1	-			1	-						
	Нэг төрлийн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болголгүй 68.0 сая төгрөгийн үйлчилгээг шууд худалдан авалт хийж, худалдан авах ажиллагааг зөрчсөн байна.	1	68.0			1	68.0						

**Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж цахимаар зохион байгуулах боломжтой албан хаагчдыг чадавхжуулах сургалт, хуулийн хэрэглээний сургалт зохион байгуулахад нийт 6.0 сая төгрөгийг зарцуулж, сургалтын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, мөн автотээврийн хэрэгслийн зогсоолын төлбөрт 2.5 сая төгрөгийг зарцуулж, тэвчиж болох үр ашиггүй зардал гаргасан байна.	1	8.5			1	8.5							
Бараа материалын дансанд тайлант оны эцэст нөөцлөх шаардлагагүй 94 нэр төрлийн 5.0 сая төгрөгийн бичиг хэрэг, хүнсний хангамжийн бараа материалын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.	1	5.0						1	5.0				
Бараа материалын дансаар дамжуулалгүй 4.4 сая төгрөгийн бичиг хэргийн материал, компьютерын гар, mouse, ном хэвлэл хангамжийн материалыг зардалд шууд бүртгэсэн байна.	1	4.4						1	4.4				
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 33 нэр төрлийн 1.9 сая төгрөгийн үнэ бүхий суурин компьютер, шүүгээ, буйдан, сандал зэрэг хөрөнгөд жилийн эцсийн байдлаар хөрөнгийн элэгдлийг байгуулаагүй байна.	1	1.9						1	1.9				
Анхан шатны баримтын бүрдэлгүй, нотлох баримтын шаардлага хангахгүй, гэрээ дүгнэсэн актгүй, гэрээ байгуулаагүй 84.5 сая төгрөгийн зарцуулалт, гадаад албан томилолтоор ажиллах захирамжгүй 3.2 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	90.7						1	90.7				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>178.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>76.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>102.0</b>	<b>-</b>	<b>-</b>	

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
ЦАУЗБУК	Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш дүнтэй 1,876.5 сая төгрөгийн орлогын 5 гүйлгээ, 1,749,7 сая төгрөгийн зарлагын 8 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.	1	3,626.2			1	3,626.2		
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>3,626.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>3,626.2</b>	<b>0</b>	<b>0</b>